



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/48

Бат-Өлзий сум

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.11 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйл, 7 дугаар зүйлийн 7.3.2, 7.3.3, 7.3.6, 7.4 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6 дахь хэсэг, “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын 2024 оны А/193 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд мал сүргийг халдварт, шимэгчтгэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг 2023 оны 03 дугаар сарын 22-оос 2024 оны 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг “Хустын-Рашаан” мал эмнэлгийн эзэн (Б.Батбилэгт), “Хутагт-Уулын өгөөж” мал эмнэлгийн захирал (П.Содномбалжир) нарт үүрэг болгосугай.

2. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын хуваарийг 1 дүгээр хавсралтаар, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2024 оны туулгалт, боловсруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар, халдваргүйтгэлийн төлөвлөгөөг 3 дугаар хавсралтаар, лабораторын төлөвлөгөөг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Бат-Өлзий сумын хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж, устгах, орчны цэвэрлэгээ ариутгалын ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн зохион байгуулахыг багийн Засаг дарга нар, мал эмнэлгийн үйлчилгээний нэгж (Хустын рашаан, Хутагт уулын өгөөж)-д тус тус үүрэг болгосугай.

4. Хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж, устгах, орчны цэвэрлэгээ, халдваргүйжүүлэх ажил, мал сүргийн халдварт шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлуудын явц, чанар үр дүнг тооцон санхүүжилтийг олгон, баримт бичгийн бүрдүүлэлт мэдээ тайланд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Мал эмнэлгийн улсын байцаагч (П.Аюушжав)-д үүрэг болгосугай.

5. Хорогдсон мал амьтны сэг зэм устгалын тайланг нэгтгэн 2024 оны 05 дугаар сарын 10-ны дотор танилцуулахыг 5 дугаар багийн Засаг дарга (Г.Бямбагарав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga



20240325

Сумын Засаг даргын 2024 оны...⁰³
дугаар сарын...⁵-ны өдрийн...²⁰²⁴
дугаар захирамжийн хавсралт



ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ВАКЦИНЖУУЛАЛТЫН ХУВААРЬ

№	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн нэр	Малын төрөл	Боом	Галзуу	ДХХ	Цусан халдварт	ДХХ- энтер
1	2	3	4	5	6	7	8
1	“Хустын-Рашаан” МЭҮН	Бод	3.0	0.8		4.0	
		Бог			8.8		6.6
2	“Хутагт-Уулын өгөөж” ХХК	Бод	2.0			2.6	
		Бог			9.4		3.0
Нийт			5.0	0.8	18.2	6.6	9.6

---oOo---

Сумын Засаг даргын 2024 оны 03
дугаар сарын 25-ны өдрийн 1148
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



ШИМЭГЧ ӨВЧНӨӨС ЭМЧЛЭН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн нэр	Малын төрөл	Угаалгад хамрагдах малын тоо	Туулгалтад хамрагдах малын тоо	Боловсруулалтад хамрагдах малын тоо	Нийт хамрагдах малын тоо
1	2	3	4	5	6	7
1	“Хустын – Рашаан” МЭҮН	бод	-	12000	7500	19500
		бог	25000	40000	20000	85000
		нохой		50	-	50
		дүн	25000	52050	27500	79550
2	“Хутагт-Уулын өгөөж” ХХК	бод		13000	7500	20500
		бог	50000	40000	20000	60000
		нохой		50	-	50
		дүн	50000	53050	27500	80550
Дүн:			75000	105100	55000	160100

---оОо---

Сумын Засаг даргын 2024 оны 03
дугаар сарын 5-ны өдрийн 11 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Арга хэмжээний нэр	Хэмжих нэгж	"Хустын-Рашаан" МЭҮН	"Хутагт-Уулын өгөөж" ХХК	Нийт тоо хэмжээ
1	2	3	4	5	6
1	Зоорь агуулах	ширхэг		1	1
		талбай, мкв		200	200
2	Малын хашаа	ширхэг	40	45	85
		талбай, мкв	28000	31500	59500
3	Худаг уст цэг	ширхэг	2	2	4
		талбай, мкв	100	100	200
4	Тэжээлийн агуулах	ширхэг			
		талбай, мкв			
5	Нийтийн эзэмшлийн талбай	ширхэг			
		талбай, мкв			
6	Тээврийн хэрэгсэл	ширхэг	5	5	10
		талбай, мкв	80	80	160
7	Мал амьтны тоног хэрэгсэл	ширхэг	10	10	20
		талбай, мкв	100	100	200
8	Түүхий эд бүтээгдэхүүн хадгалах цэг	ширхэг		1	1
		талбай, мкв		500	500
9	Голомтын бүсийн талбай	ширхэг			
		талбай, мкв			
10	Устгалын цэгийн талбай	ширхэг	3	3	6
		талбай, мкв	1500	1500	3000
11	Өтөг бууц	ширхэг			
		талбай, мкв			
12	Бэлчээрийн талбай	ширхэг			
		талбай, мкв	500	500	1000
Нийт талбай, метр.кв			30280	34480	64760

Сумын Засаг даргын 2024 оны 03
дугаар сарын 15-ны өдрийн 14 дугаар
захирамжийн дөрөвдүгээр хавсралт

ЛАБОРАТОРИЙН ТАНДАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн нэр	Малын төрөл	Бруцеллэз	Баас	Сүү	Арьсны сорил	
						ям	сүрьеэ
1	2	3	4	5	6	7	8
1.	"Хустын – Рашаан" МЭҮН	Хуц	170	20	40	-	-
		Ухна	120				
		Бух	75				
		Дүн	365				
2.	"Хутагт-Уулын өгөөж" ХХК	Хуц	140	25	-	-	-
		Ухна	130				
		Бух	60				
		Дүн	330				
Дүн:			695	45	40	-	-

---oOo---